



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Иргэдийн гомдол, саналыг
хүлээн авах, тайлагнах тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийг хэрэгжүүлэх, иргэдээс ирүүлсэн гомдол, саналыг шуурхай барагдуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын асуудлаар иргэдийг хүлээн авч, тэдний санал хүсэлтийг сонсох “Уулзалтын өрөө” ажиллуулсугай.
2. Яамны газар, хэлтсийн дарга нарын иргэдтэй уулзах хуваарийг Нэгдүгээр хавсралтаар баталж, 2015 оны 05 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдүүлсүгэй.
3. Уулзалтын өрөөг камержуулах, иргэдийг нэвтрүүлэхэд шаардлагатай техник, хэрэгслэлээр хангах, тохижуулахад шаардлагатай зардлыг тооцож, төсөв хөрөнгө гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга (Т.Баярсайхан) ерөнхий нягтлан бодох (Д.Даваадулам) нарт зөвшөөрсүгэй.
4. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн санал гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж, тайланг улирал тутам, дараа сарын 15-ны дотор уг тушаалын хоёрдугаар хавсралтын хамт ирүүлж байхыг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, харьяа байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 312 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

090530

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 22 өдрийн
15.4 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт


ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ УДИРДЛАГА,
ГАЗАР, ХЭЛТСИЙН ДАРГА НАРЫН ИРГЭДТЭЙ УУЛЗАХ ХУВААРЬ

д/д	Уулзах өдөр, цаг			Уулзах хүний нэр, албан тушаал
1	Даваа	Сарын бүрийн 1, 3 дугаар 7 хоног	14.00-16.00	Б.Эрдэнэчимэг, ТЗУГ-ын дарга
		Сарын 2, 4 дүгээр 7 хоног		Л.Зэндмаа, ЭТХ-ийн дарга
2	Мягмар	Сарын бүрийн 1, 3 дугаар 7 хоног	14.00-16.00	Р.Оюунханд, СБТГ-ын дарга
		Сарын 2, 4 дүгээр 7 хоног		М.Уранчимэг, ЭЭХХ-ийн дарга
3	Лхагва	Сарын бүрийн 1, 3 дугаар 7 хоног	14.00-16.00	О.Баяр, ЭМБХЗГ-ын дарга
		Сарын 2, 4 дүгээр 7 хоног		Э.Оюунсүрэн, ХШУДАГ-ын дарга
4	Пүрэв	Сарын бүрийн 1, 3 дугаар 7 хоног	14.00-16.00	Х.Бакытжан, НБТСБХЗГ-н дарга
		Сарын 2, 4 дүгээр 7 хоног		П.Оюунцэцэг, НЭМХ-ийн дарга
5	Даваа, Лхагва, Пүрэв, Баасан		9.00-11.00	Т.Баярсайхан, СЭЗХ-ийн дарга

Жич:

- Сайд, дэд Сайд, Төрийн нарын бичгийн даргын иргэдийг хүлээн авах асуудлыг ажлын алба, туслахууд зохицуулна.

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 22 өдрийн
15.4 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



.....оныулиралд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хүснэгт -1

Улирал	Өргөдөл гомдлын тоо		Шийдвэрлэлт			
	Тайлангийн улиралд	Тайлант улирлын байдлаар, өссөн дүнгээр	Шийдвэрлэж хариу өгсөн	Хугацаа хэтрүүлсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Шийдвэрлэлт %
1						
2						
3						
4						

Өргөдөл, гомдлын төрөл

Хүснэгт -2

д/д	Төрөл	Бодит тоо	Нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
1	Нийт:		
2	Талархал		
3	Санал		
4	Гомдол		
5	Хүсэлт		

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

Хүснэгт -3

Байгууллага нэр	Өргөдөл гомдлын тоо	Үүнээс					
		Бичгээр	11-11 төвөөр	цахимаар	утсаар	биечлэн	бусад

Өргөдөл, гомдлын агуулга

Хүснэгт -4

д/д	Төрөл	Өргөдөл гомдлын нийт тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1.	Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой		
2.	Эмч ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой		
3.	Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой		
4.	Ажилтнуудын нийгмийн асуудалтай холбоотой		
5.	бусад		